НЗД-ын 1993 оны 282-р тогтоолоор хүчингүй. 252

БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

# ТОГТООЛ

1990 оны 5 дугаар сарын 22-ны өдөр

дугаар 94

Улаанбаатар хот

Хотын хөдөө аж ахуй,хүнсний үйлдвэрийн салбарыг удирдах ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 161 дүгээр тогтоолыг удирдлага болгон хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

НЭГ.Улаанбаатар хотын АДХ-ын шууд харьяанд Талх чихрийн болон Архи пивоны комбинат, сүү, талх, чихэр боов, хүүхдийн сүүн тэжээлийн үйлдвэрүүд шилжин ирсэнтэй холбогдуулан хотын хөдөө аж ахуйг удирдах газрыг өргөтгөн хотын хөдөө аж ахуй хүнсний үйлдвэрийг удирдах газар болгон 1990 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн шинээр зохион байгуулж ажиллуулсугай.

I. Хөдөө аж ахуй хүнсний үйлдвэрийг удирдах газрын 1990-1995 онд тогтвортой мөрдөх сарын цалингийн санг 14,6 мянган төгрөгөөр баталсугай.

[illegible]

ХОЁР.Хотын хөдөө аж ахуй хүнсний үйлдвэрийг удирдах газар /н.Мижиддорж/-д ДААЛГАХ нь:

1.Хотын хөдөө аж ахуй хүнсний үйлдвэрийг удирдах газрыг хэлтэсгүй зохион байгуулж, түүгээр батлагдсан сарын цалингийн сандаа багтаан ажлын мэдлэг, дадлага туршлагатай, гүйцэтгэх сахилга өндөртэй мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлэх арга хэмжээг 1990 оны эхний хагаст багтаан авах.

2.БНМАУ-ын үйлдвэрийн газрын хуулийг удирдлага болгон харьяа аж ахуй, хүнсний үйлдвэрүүдийн бие даасан ажиллагааг хангаж,гэрээ, түрээсийн хэлбэр, аж ахуйн дотоод тооцоог туштай нэвтрүүлж, аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд нь дүн шинжилгээ хийж,тэднийг эдийн засгийн аргаар алс хэтийн хараатай удирдаж ажиллах.

2.

ГУР.Б.Хотын АДХ-ын шууд мэдэлд шилжин ирж байгаа хүнсний үйлдвэрүүдийг тусгай групп томилон хүлээн авч, эдгээр үйлдвэрүүдийн талаар цаашид авах арга хэмжээг боловсруулан энэ оны III улиралд багтаан шийдвэрлүүлэхийг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны нэгдүгээр орлогч /Н.Сумаахүү/-д даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА Л.ЭНЭБИШ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Д.АЛГИА